



**ЦАХИМ ХӨГЖИЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ**

**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2024 он**

УДИРТГАЛ

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Уг аргачлалд заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцсон болно.

Иймд хуулийн төслийн зардлыг урьдчилан тооцоходоо түүнийг хэрэгжүүлэх төрийн байгууллага болон хуулийн этгээдэд үүсэх зардлыг тоймлон гаргах, хуулийн төслөөр шинээр бий болгож байгаа үүргийн хүрээнд зардал үүсгэх боломжтой зүйл, заалтуудыг авч үзэн зардал тус бүрээр тооцож, мөн эдгээр байгууллагад үүсэх зардал, ачааллыг бууруулах боломжтой эсэхийг судлан, боломжит хувилбарыг дэвшүүлэхийг зорьсон.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан болно. Үүнд:

- гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

Нэг.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардал

Энэхүү хуулийн төслийн төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр нэг албан хаагчид шаардагдах зардлаар үржүүлэн тооцох замаар дараах үе шаттайгаар гаргалаа. Үүнд:

1. Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хугацааг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тогтоох;
3. Хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох;
4. Бусад зардал буюу материаллаг зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягтлах.

Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг нэг бүрчлэн түүвэрлэн, хийж гүйцэтгэх үйл явцын дагуу уялдаа холбоог харгалзан тодорхойлсон. Ийнхүү тодорхойлохдоо ажил үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамааруулах нь зүйтэй.

Үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг тооцохдоо төрийн байгууллагад хийгддэг адил төстэй үйлчилгээг судалж, холбогдох мэргэжилтнүүдийн ажилбарт ажлын байрны зураг авалтын үр дүнд гаргасан хугацаан дээр үндэслэн тэдгээрийн гүйцэтгэх хугацааг тодорхойлон тооцлоо.

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200¹ өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу /200 x 8/ 1600 ажлын цаг буюу /1,600 x 60/ 96000 минут ажиллана.

1.Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн Хоёрдугаар бүлэгт Засгийн газар мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар тодорхой бүрэн эрхтэй байхаар хуулийн холбогдох зүйл, заалтуудад тусгасан. Иймд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт үүсэх хүний нөөцийн зардлыг доор дурдсан заалтуудыг сонгон авч тооцох болно.

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт /5 дугаар зүйл/
Төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах бодлого, стратеги төлөвлөгөө, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хүн, хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;
Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах;

¹Хуулийн 365 хоногоос хөдөлмөрийн хуулинд заасан нийтээр амрах байрын өдөр, ээлжийн амралт, хагас бүтэн сайн өдөр зэргийг хасаж бодитой ажиллах өдрийг тооцно.

Хүн, хуулийн этгээдийн мэдээллийн технологийн үйлдвэрлэлд олгох грант, урамшууллын хэмжээ, зээлийн батлан даалт гаргах журам, нөхцөлийг тогтоох;
Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс байгуулах;
Энэ хуулийн 4.1.7-д заасан дэвшилтэт технологийн жагсаалтыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;
Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээг батлах;
Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндроксын журмыг батлах.

Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн
төрийн захиргааны төв байгууллага

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн Хоёрдугаар бүлэгт цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар холбогдох чиг үүргийг гүйцэтгэхээр хуулийн холбогдох зүйл, заалтуудад тусгасан. Иймд тус байгууллагад үүсэх хүний нөөцийн зардлыг доор дурдсан заалтуудыг сонгон авч тооцох болно.

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт /7 дугаар зүйл/
Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотой стандарт, тушаал шийдвэр, дүрэм, журмыг боловсруулж, батлах;
Бүх нийтийн цахим ур чадварын түвшинг үнэлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах;
Мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийх, хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт, нийлүүлэлтийг хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;
Мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах, бодлогын судалгаа шинжилгээ хийх;

Хуулийн төсөлд тусгасан “Хүн, хуулийн этгээдээс худалдан авах мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэг цонхны системийг бүрдүүлэх” чиг үүргийн хүрээнд программ хангамжийн их дэлгүүр буюу “Mindgolia.mn” системийг хөгжүүлж, ашиглагдаж байгаа тул зардал тооцох шаардлагагүй гэж үзэж хассан болно.

Мэдээлэл, технологийн үндэсний парк

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн Хоёрдугаар бүлэгт Мэдээлэл, технологийн үндэсний парк мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар холбогдох чиг үүргийг гүйцэтгэхээр хуулийн холбогдох зүйл, заалтуудад тусгасан байна. Тус паркийн хэрэгжүүлэх чиг үүргийг хуулийн төсөлд тусгахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 60 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрмээс авсан байх тул одоо хэрэгжүүлж байгаа зарим чиг үүрэгт зардал тооцох шаардлагагүй гэж үзлээ. Тус байгууллагад шинээр бий болгосон чиг үүргийн хүрээнд үүсэх хүний нөөцийн зардлыг доор дурдсан заалтуудыг сонгон авч тооцох болно.

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт /8 дугаар зүйл/
мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэх;
мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд хуулийн этгээдийг бүртгэх, хуульд заасан үндэслэлээр бүртгэлээс хасах;

2.Хүний нөөцийн хэрэгцээг тогтоох

2.1.Хуулийн төсөлд тусгагдсан Засгийн газарт нэмэлт эрх, үүрэг үүсгэж байгаа онцлогоос хамаарч давтамжийг өөр өөрөөр тогтоолоо.

Мэдээлэх үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Давтамж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
5.1.1.төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах бодлого, стратеги төлөвлөгөө, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хүн, хуулийн этгээдэд татварын болон	Хууль тогтоомжийн төслийн боловсруулалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан хийхгүй бөгөөд мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Хууль тогтоомжийн төсөлтэй танилцах, мэдээллээ үнэлэх	2 өдөр /16 цаг/ 960 мин	2	1920 мин
		Хууль тогтоомжийн төслийг хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	2	480 мин

татварын бус дэмжлэг үзүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	боловсруулалтыг хийж, ЗГХЭГ-т хүргүүлэн, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлэх ажлыг хариуцан ажиллахаар байх тул зардлыг тус агуулгаар хийх нь зүйтэй.				
5.1.2.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах;	Нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмын төслийн боловсруулалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан хийхгүй бөгөөд мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулалтыг хийж, ЗГХЭГ-т хүргүүлэн, батлах үйл явцыг ЗГХЭГ хариуцан ажиллахаар байх тул зардлыг тус агуулгаар хийх нь зүйтэй.	Нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмын төсөлтэй танилцах, мэдээллээ үнэлэх	1,0 өдөр /8 цаг/ 480 мин	5 /Хуулийн төслийн хүрээнд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх журам, жагсаалтын тоо/	2400 мин
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	5	1200 мин
5.1.3.хүн, хуулийн этгээдийн мэдээллийн технологийн үйлдвэрлэлд олгох грант, урамшууллын хэмжээ, зээлийн батлан даалт гаргах журам, нөхцөлийг тогтоох;	Журмын төслийн боловсруулалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан хийхгүй бөгөөд мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Журмын төсөлтэй танилцах, мэдээллээ үнэлэх	1,0 өдөр /8 цаг/ 480 мин	1	480 мин
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240 мин

	боловсруулалт ыг хийж, ЗГХЭГ-т хүргүүлэн, батлах үйл явцыг ЗГХЭГ хариуцан ажиллахаар байх тул зардлыг тус агуулгаар хийх нь зүйтэй.				
5.1.4.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс байгуулах;	Виртуал бүс байгуулах Засгийн газрын шийдвэрийн төслийн боловсруулалт ыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан хийхгүй бөгөөд мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулалт ыг хийж, ЗГХЭГ-т хүргүүлэн, батлах үйл явцыг ЗГХЭГ хариуцан ажиллахаар байх тул зардлыг тус агуулгаар хийх нь зүйтэй.	Шийдвэрийн төсөлтэй танилцах, мэдээллээ үнэлэх	1,0 өдөр /8 цаг/ 480 мин	1	480 мин
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240 мин
5.1.6.энэ хуулийн 4.1.7-д заасан дэвшилтэт технологийн жагсаалтыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;	Жагсаалтын төслийн боловсруулалт ыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан хийхгүй бөгөөд мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулалт ыг хийж, ЗГХЭГ-	Жагсаалтын төсөлтэй танилцах, мэдээллээ үнэлэх	1,0 өдөр /8 цаг/ 480 мин	1	480 мин
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240 мин

	т хүргүүлэн, батлах үйл явцыг ЗГХЭГ хариуцан ажиллахаар байх тул зардлыг тус агуулгаар хийх нь зүйтэй.				
5.1.7.бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээг батлах;	Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээний төслийн боловсруулалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан хийхгүй бөгөөд мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулалтыг хийж, ЗГХЭГ-т хүргүүлэн, батлах үйл явцыг ЗГХЭГ хариуцан ажиллахаар байх тул зардлыг тус агуулгаар хийх нь зүйтэй.	Бүтцийн хүрээний төсөлтэй танилцах, мэдээллээ үнэлэх	1,0 өдөр /8 цаг/ 480 мин	1	480 мин
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240 мин
5.1.8.хиймэл оюун ухаан, их өгөгдөл, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндроксын журмыг батлах.	Журмын төслийн боловсруулалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан хийхгүй бөгөөд мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулалтыг хийж,	Журмын төсөлтэй танилцах, мэдээллээ үнэлэх	1,0 өдөр /8 цаг/ 480 мин	1	480 мин
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240 мин

	ЗГХЭГ-т хүргүүлэн, батлах үйл явцыг ЗГХЭГ хариуцан ажиллахаар байх тул зардлыг тус агуулгаар хийх нь зүйтэй.				
Нийт					9600 мин

2.2.Хуулийн төсөлд тусгагдсан цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэмэлт чиг үүрэг үүсгэж байгаа онцлогоос хамаарч давтамжийг өөр өөрөөр тогтоолоо.

Мэдээлэх үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Давтамж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотой стандарт, тушаал шийдвэр, дүрэм, журмыг боловсруулж, батлах;	Стандарт, дүрэм, журмын төсөл боловсруулах, батлах	Мэдээллээ цуглуулах, үнэлэх	7 өдөр /56 цаг/ 3360 мин	10	33600 мин
		Боловсруулалт хийх	30 өдөр /240 цаг/ 14400 мин	10	144000 мин
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	10	2400 мин
	Тушаал, шийдвэрийн төсөл боловсруулах, батлах	Мэдээллээ цуглуулах, үнэлэх	3 өдөр /24 цаг/ 1440 мин	10	14400 мин
		Боловсруулалт хийх	7 өдөр /56 цаг/ 3360 мин	10	33600 мин
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	10	2400 мин
Бүх нийтийн цахим ур чадварын түвшинг үнэлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах	Сургалт зохион байгуулах, үнэлэх	Сургалтад хамрагдах этгээдийг үнэлэх	30 мин	100 /21 аймаг, 9 дүүрэг, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад /	3000 мин
		Сургалтын бэлтгэл ажлыг хангах	1,0 өдөр /8 цаг/ 480 мин	100	48000 мин

		Сургалт зохион байгуулах	1,0 өдөр /8 цаг/ 480 мин	100	48000 мин
Мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийх	Мэдээллийн технологийн салбарын мэдээлэл цуглуулах, судалгаа хийх	Мэдээллээ цуглуулах, үнэлэх	14 өдөр /112 цаг/ 6720 мин	1	6720 мин
		Судалгааны материал боловсруулах	30 өдөр /240 цаг/ 14400 мин	1	14400 мин
Мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах, бодлогын судалгаа шинжилгээ хийх	Бодлогын судалгаа, шинжилгээ хийх	Мэдээллээ цуглуулах, үнэлэх	7 өдөр /56 цаг/ 3360 мин	2	6720 мин
		Гадаад улс орнуудын туршлага судлах, орчуулах	30 өдөр /240 цаг/ 14400 мин	2	28800 мин
		Судалгааны материал боловсруулах	60 өдөр /480 цаг/ 28800 мин	2	57600 мин
Нийт					442,440 мин

2.3.Хуулийн төсөлд тусгагдсан Мэдээлэл, технологийн үндэсний паркд нэмэлт чиг үүрэг үүсгэж байгаа онцлогоос хамаарч давтамжийг өөр өөрөөр тогтоолоо.

Мэдээлэх үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Давтамж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэх;	Тушаал, шийдвэрийн төсөл боловсруулах, батлах	Мэдээллээ цуглуулах, үнэлэх	1 өдөр /8 цаг/ 480 мин	10	4800 мин
		Боловсруулалт хийх	3 өдөр /56 цаг/ 3360 мин	10	33600 мин
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	10	2400 мин
	Сургалт зохион байгуулах	Сургалтын бэлтгэл ажлыг хангах	1,0 өдөр /8 цаг/ 480 мин	4	1920 мин
		Сургалт зохион байгуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	4	9600 мин

	Гомдол шийдвэрлэх	Хариуг боловсруулж хүргүүлэх	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	450	108000 мин
	Зөвлөгөө өгөх	Биечлэн	10 мин	150	1500 мин
		Утсаар	2 мин	150	3000 мин
		Цахимаар	5 мин	150	750 мин
Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд хуулийн этгээдийг бүртгэх, хуульд заасан үндэслэлээр бүртгэлээс хасах;	Хуулийн этгээдийг бүртгэх, хуульд заасан үндэслэлээр бүртгэлээс хасах;	Хуулийн этгээдийн баримт бичигтэй танилцах, судлах	120 мин	450	54000 мин
		Хуулийн этгээдийг системд бүртгэх	30 мин	450	13500 мин
		Хуулийн этгээдийг виртуал бүсэд бүртгэсэн талаар мэдэгдэх	15 мин	450	6750 мин
Нийт					239,820 мин

3.Хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох

3.1.Засгийн газрын хэрэгжүүлэх үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг дараахь байдлаар гаргалаа.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг/мин	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	9600 мин	96000	0.1

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргана.

*Төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон
төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ*

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ
ТЗ-1	2,562,000
ТЗ-2	2,440,000

T3-3	2,302,000
T3-4	2,171,000
T3-5	2,048,000
T3-6	1,933,000
T3-7	1,757,000
Дундаж цалин	2,173,285

Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128

дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ажлын хөлсийг тогтоохдоо “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 128 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ”-ээс дундаж цалингийн хэмжээг тооцож, холбогдох нэмэгдлүүдийг тооцохгүйгээр **сарын дундаж цалинг 2,173,285 төгрөг** байхаар тооцов.

Хүний нөөцийн зардал

Нэгж	Цалингийн зардал /төг/	Орон тооны ачаалал	Сар	Хүний нөөцийн нийт зардал /төг/
ЗГХЭГ	2,173,285	0.1	12	2,607,942
Нийт хүний нөөцийн зардал жилд				2,607,942

3.2.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа тус бүрд зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг дараах байдлаар гаргалаа.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг/мин	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	442,440 мин	96000	4.6

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргана.

Төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ
T3-1	2,562,000
T3-2	2,440,000
T3-3	2,302,000
T3-4	2,171,000
T3-5	2,048,000
T3-6	1,933,000
T3-7	1,757,000
Дундаж цалин	2,173,285

Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ажлын хөлсийг тогтоохдоо “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 128 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ”-ээс дундаж цалингийн хэмжээг тооцож, холбогдох нэмэгдлүүдийг тооцохгүйгээр **сарын дундаж цалинг 2,173,285 төгрөг** байхаар тооцов.

Хүний нөөцийн зардал

Нэгж	Цалингийн зардал /төг/	Орон тооны ачаалал	Сар	Хүний нөөцийн нийт зардал /төг/
ЗГХЭГ	2,173,285	4.6	12	9,997,111
Нийт хүний нөөцийн зардал жилд				9,997,111

3.3.Мэдээлэл, технологийн үндэсний паркийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа тус бүрд зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг дараах байдлаар гаргалаа.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг/мин	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Мэдээлэл, технологийн үндэсний парк	239,820 мин	96000	2.5

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр Мэдээлэл, технологийн үндэсний паркад үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргана.

Хүний нөөцийн зардал

Нэгж	Цалингийн зардал /төг/	Орон тооны ачаалал	Сар	Хүний нөөцийн нийт зардал /төг/
Мэдээлэл, технологийн үндэсний парк	1,700,000 /МТҮП дахь цалингийн дундаж хэмжээ/	2.5	12	4,250,000
Нийт хүний нөөцийн зардал жилд				4,250,000

4.Бусад зардал буюу материаллаг зардлыг нэгтгэн тооцох

Материаллаг зардалд тухайн үүргийг гүйцэтгэж буй нэг албан хаагчийг ажиллах нөхцөлөөр хангахад зарцуулж буй зардлыг ойлгоно. Тухайлбал албан хаагчийн ажлын байр, өрөө тасалгаа, техник хэрэгсэл, шаардлагатай бусад зардлыг энд тооцох хэрэгтэй. Ингэхдээ дээрх зардлуудын дийлэнхийг, тухайлбал урсгал зардлыг /халаалт, цэвэр, бохир ус, цахилгаан, урсгал засвар гэх зэрэг/ үйлчилгээний байр тус бүрээр ерөнхий байдлаар гаргадаг тул 1 ажилтанд зарцуулах материаллаг зардлыг нарийвчлан тооцож гаргах боломжгүй юм. Иймд “Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал”-д жишээ болгон авсан нэг ажилтны материаллаг зардлыг ашиглав.

Нийт дүнг тооцохдоо төрийн байгууллагаас гарах нийт зардлыг тооцох бөгөөд хүний нөөцийн зардал, материаллаг зардал, бусад зардлын нийлбэрээр нийт зардлыг тооцон гаргана.

**Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай
хуулийн төслийн хүрээнд гарах материаллаг зардлын тооцоо**

№	Зардлын нэрс	Хуулийн хэрэгжилттэй холбоотой гарах нэмэлт зардал нэгжээр	Тоо хэмжээ	Нийт үнэ
1	Бичиг хэргийн материал	1,016,445	1	1,016,445
2	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	180,734	1	180,734
3	Хангамжийн материал	543,331	1	543,331
4	Бусад зардал	48,766	1	48,766
Дүн		1,789,276		1,789,276

Үүнээс харахад улсын бүртгэлийн нэг ажилтанд гарах материаллаг зардлын хэмжээ дунджаар 1,789,276 /нэг сая долоон зуун наян есөн мянга хоёр зуун далан зургаа/ төгрөг бөгөөд цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллага, Мэдээлэл, технологийн үндэсний паркард шаардлагатай хүний нөөц /7.1/-д үржүүлэн тооцвол нийт дүн 12,703,859 төгрөг болохоор байна.

Төрийн байгууллага, түүний чиг үүргийг гүйцэтгэгч этгээдэд үүсэх нийт зардлыг тооцоход жилд:

$$16,855,053 + 12,703,859 = 29,558,912 \text{ төгрөг байна.}$$

5.Хувилбарыг нягтлах

Хялбарчлах боломжийг шалгаж, үр дүнг танилцуулах ажлыг энэхүү үе шатанд хийж гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, төсвийн зардлыг багасгах боломж бий эсэх, зохицуулалтын өөр хувилбар байгаа эсэх, ачаалал бууруулах боломжтой эсэхийг тогтооно.

Д/д	Асуулт	Хариулт	Тайлбар
1.	Боловсруулан, батлах журмын тоог багасгах	Боломжгүй	Хуулиар үүрэгжүүлсэн.
2.	Судалгааны мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх	Боломжгүй	Судалгаа ач холбогдолгүй болно.
3.	Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх	Боломжтой	Өмнө нь хийгдэж байсан ажлууд бөгөөд Захиргааны ерөнхий хуультай нийцүүлэн дэлгэрэнгүй байдлаар хуульчлагдсан.
4.	Зарим баримт бичгийг боловсруулах хугацааг багасгах боломжтой эсэх	Боломжтой	
5.	Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх	Боломжгүй	Мэдээллийн хүртээмж буурна.

Дүгнэлт

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад жилд нийт 29,558,912 төгрөгийн зардал гарахаар тооцов.

Хуулийн төсөлд тусгагдсан зарим үүргүүд нь одоо хийгдэж байгаа ажиллагааг нарийвчлан хуульчилж өгсөн тул нэмэлтээр үүсэх зардал буурах боломжтой. Түүнчлэн гомдол гаргах, зөвлөгөө авах, виртуал бүсэлд бүртгэл хийлгэх тохиолдлын тоог статистик тоон мэдээнээс өндрөөр тооцсон тул энэ тохиолдлын тоо буурч зардал буурах боломжтой байна.

Дээрх зардал тооцогдсон хуулийн заалтын хүрээнд хийгдэх үйл ажиллагаануудыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллага, Мэдээлэл, технологийн үндэсний парк нь өөрийн үйл ажиллагаанд зохион байгуулалт хийх, албан тушаалын тодорхойлолтод зарим өөрчлөлт хийх замаар төсөвт ачаалал үүсгэхгүйгээр хийх боломжтой гэж дүгнэлээ.

Харин хуулийн төсөлд Засгийн газар, Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэдээлэл, технологийн үндэсний парсад үүсэх хүний нөөцийн зардал, материаллаг зардал болон бусад зардлаас гадна мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч нарт үзүүлэх дэмжлэгийн эх үүсвэрийг санхүүжүүлэхтэй холбоотой зардлыг тооцох шаардлагатай.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлд мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн 40-өөс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө, гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусламж, энэ хуулийн 7.4-т заасны дагуу төсвийн байгууллагын өөрийн эзэмшиж байгаа программ хангамжийн эх кодыг гадаад улсын хуулийн этгээдэд эзэмшүүлснээс орсон орлого, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.5, 5.3.10, 5.3.20-д заасан Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн 5-аас доошгүй хувийг виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийг дэмжихэд зарцуулахаар тусгасан байна.

Эдгээр зардлаас мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн 40-өөс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө нь улсын төсвөөс санхүүжих зардал байх ба харин хандив, тусламж, өөрийн эзэмшиж байгаа программ хангамжийн эх кодыг гадаад улсын хуулийн этгээдэд эзэмшүүлснээс орсон орлого нь улсын төсөвт ачаалал үүсгэхээргүй байна. Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.5-д заасан Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, 5.3.10-д заасан Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сан, 5.3.20-д заасан Шинжлэх ухаан, технологийн сангуудын хөрөнгө нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарт буюу гарааны компаниудыг дэмжих зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох, өмчийн хэлбэр үл харгалзан мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид олгох тэтгэлэг, бусад дэмжлэг үзүүлэх, мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт, мэргэшүүлэх сургалтын зардал, инновацийн төсөл хэрэгжүүлэх, гарааны санхүүгийн дэмжлэг олгох, технологи, үйлдвэрлэлийн туршилт, зүгшрүүлэлтэд дэмжлэг үзүүлэх зэрэгт зарцуулахаар зохицуулсан тул Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн 5-аас доошгүй хувийг виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийг дэмжихэд зарцуулахаар тусгасан зохицуулалтын хүрээнд зардал тооцох

шаардлагагүй болно. Өөрөөр хэлбэл виртуал бүсэд бүртгэгдэх хуулийн этгээд нь мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч, шинэ технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх компаниуд байх тул дээрх сангуудаас явуулж байгаа үйл ажиллагааны хүрээнд дэмжлэг авах боломжтой учир төсвөөс нэмж мөнгөн хөрөнгө тусгах шаардлагагүй байна.

Харин дээр дурдсан мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн 40-өөс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө нь хэдий хэмжээний зардал үүсгэхээр байгааг тооцож үзье. Сангийн яамнаас улсын төсөвт тодорхой салбараас төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг нарийвчлан тооцоолоход хүндрэлтэй байдаг тухай тодруулсан тул мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс орж байгаа орлогын талаарх дүн мэдээнд үндэслэн түүнээс татвар тооцож улсын төсөвт цугларсан мөнгөн хөрөнгийг уг зардал байхаар тооцооллоо. Үндэсний статистикийн газрын <https://www.1212.mn/> сайтаас мэдээлэл, харилцаа холбооны салбарын орлогын талаарх дүн мэдээг тодруулахад Компьютер программчлал, зөвөлгөө болон түүнд холбогдох үйл ажиллагаанаас сүүлийн 3 жилийн хугацаанд буюу 2021 онд 144 тэрбум, 2022 онд 130 тэрбум, 2023 онд 222 тэрбум төгрөгийн орлого олсон байх ба дунджаар 165 тэрбум төгрөг байна. Улсын төсөвт нийт төвлөрүүлсэн хөрөнгө нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасны дагуу мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч нарын үйл ажиллагаанд ногдуулж байгаа албан татварын орлогоос бүрдэх тул энэ талаарх эрх зүйн орчныг тодруулж, зохих тооцооллыг хийх нь зүйтэй.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.2.7-д тус хуулийн 20.1-д заасныг үл харгалзан энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан жилийн 300 сая төгрөг хүртэл албан татвар ногдох орлого олсон, энэ хуулийн 22.1.1, 22.1.2, 22.1.3-т зааснаас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн тухайн албан татвар ногдуулах орлогод 1 хувиар, 20.1-д зааснаар тус хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасны дагуу тодорхойлоход 0-6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 10 хувиар, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 25 хувиар нэмж албан татвар ногдуулахаар тус тус зохицуулсан байна.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэл бүрт ногдуулж байгаа аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг нэг бүрчлэн тооцох боломжгүй бөгөөд үзэл баримтлалд дурдсанаар мэдээллийн технологийн бизнес эрхлэгчдийн ихэнх нь гарааны

компаниуд байх тул тухайн үйл ажиллагааны орлого нь 300 сая төгрөг хүртэлх гэж тооцох шаардлагатай. Иймд мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч нарын ихэнх буюу 80 гаруй хувь нь гарааны бизнес хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа гэж үзэн өмнө дурдсан 165 тэрбум төгрөгийн орлогын 80 хувьтай тэнцэх хэмжээний буюу 132 тэрбум төгрөгийн орлогоос 1 хувийн татвар тооцоход 1,3 тэрбум төгрөг, харин 165 тэрбум төгрөгийн орлогын 20 хувьтай тэнцэх хэмжээний буюу 33 тэрбум төгрөгийн орлогоос 10 хувийн татвар тооцоход 3,3 тэрбум төгрөг болж нийтдээ улсын төсөвт 4,6 тэрбум төгрөг төвлөрүүлсэн гэж үзэхээр байна. Мөн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 11.1-д тус хуулийн 7.1.1, 7.1.2-т заасан бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын үнэлгээнд 10 хувиар ногдуулахаар заасан бөгөөд 165 тэрбум төгрөгийн орлогоос 10 хувийн татвар тооцоход 16,5 тэрбум төгрөг байхаар байна. Иймд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас нийтдээ 21 орчим тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн гэж үзвэл 40-өөс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө нь 8.4 тэрбум төгрөг байхаар тооцоолол гарч байна. Энэ зардал нь тухайн жилийн санхүү, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан бусад хууль тогтоомжийн нэгэн адил улсын төсвөөс шийдвэрлэгдэхгүй байх магадлалтайг харгалзан хууль хэрэгжсэнээр төрийн байгууллага, төрийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа байгууллагад үүсэх хүний нөөцийн зардал, материаллаг зардал болон бусад зардалд оруулан тооцоогүй болно.

Хоёр.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд үүсэх зардал

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлд хуулийн этгээдэд мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгүүлэхдээ улсын бүртгэлийн гэрчилгээний мэдээлэл, ажилтныг нийгмийн даатгалд хамруулсан эсэх тухай нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт, эхлэлтийн баланс, эсхүл өмнөх жилийн санхүүгийн тайлангийн мэдээллийг ирүүлэх үүргийг тодорхойлсон байх ба гэхдээ улсын бүртгэлийн гэрчилгээний мэдээлэл, ажилтныг нийгмийн даатгалд хамруулсан эсэх тухай нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолтыг Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс татаж харах боломжтой тул энэ төрлийн мэдээллийг давхардуулан ирүүлэхгүй шаардлагагүй байна. Харин өмнөх жилийн санхүүгийн тайлангийн мэдээллийг ирүүлэх хэрэгцээ шаардлага байна. Хуулийн этгээд нь виртуал бүсэд бүртгүүлэх, гэрээ байгуулах зорилгоор ирж, буцах зардлаас бусад тохиолдолд зардал тооцохгүй болно.

Хүсэлт гаргагчийн байрладаг байршил, ашиглах тээврийн хэрэгслийн хэлбэр түүний зарцуулах зардал харилцан адилгүй байна. Тухайлбал, нийтийн тээврийн хэрэгслээр зорчиж Мэдээлэл, технологийн үндэсний паркт очих болон буцах зардалд 500Х2 буюу 1000 төгрөг, харин таксины үйлчилгээ авсан тохиолдолд зардлыг зах зээлийн дундаж үнэлгээгээр тооцвол 10000Х2 буюу 20000 төгрөг гарах магадлалтай байна. Харин бүртгэлийг цахим хэлбэрээр хийлгэх, гэрээг цахим хэлбэрээр байгуулах тохиолдолд хуулийн этгээдэд ямар нэгэн зардал үүсэхээргүй байна.

№	Зардлын нэрс	Хуулийн хэрэгжилттэй холбоотой гарах нэмэлт зардал нэгжээр	Тоо хэмжээ	Нийт үнэ
1	Ирж, буцах зардал /нийтийн тээвэр/	1000	450	450,000
2	Ирж, буцах зардал /Такси/	20000	450	9,000,000

Гурав.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардал

Хуулийн төсөлд иргэний гүйцэтгэх үүргийг тусгаагүй, үүрэгжүүлсэн зохицуулалт байхгүй тул зардал тооцох шаардлагагүй болно.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалд заасны дагуу хэмжигдэхүйц зардлыг тооцсон болно. Үүнд:

1.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн хүрээнд төрийн байгууллага, төрийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэх байгууллага болох Засгийн газар, Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэдээлэл, технологийн үндэсний паркийн хариуцах нэмэлт чиг үүргийг тусгасан. Иймд эдгээр заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлыг аргачлалын 4.3.3-т заасны дагуу хэмжих боломжтой ажлыг тооцсон бөгөөд хуулийн төслийн заалтуудад заасан ажиллагааг хэрэгжүүлэх зардлыг тооцоход нийт төрийн байгууллага, төрийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа байгууллагад жилд нийт **29,558,912 төгрөгийн** зардал үүсэхээр байна.

2.Хуулийн төсөлд тусгагдсан хуулийн заалттай холбоотой хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцохдоо мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгүүлэх, гэрээ байгуулах зорилгоор Мэдээлэл, технологийн үндэсний паркт ирж, буцахад шаардлагатай унаанд мэдээллийн технологийн чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 450 компани гэж зардлыг тооцоход нийтийн тээврээр үйлчлүүлсэн тохиолдолд 450,000 төгрөгийн буюу нэг компанид 1000 төгрөгийн, таксины үйлчилгээ авсан тохиолдолд дунджаар 9,000,000 төгрөгийн буюу нэг компанид 20000 төгрөгийн зардал үүсэхээр байна. Гэхдээ бүртгэл, гэрээ байгуулах ажлыг цахим хэлбэрээр хийх боломжтойг хуулийн төсөлд тусгасан бөгөөд энэ тохиолдолд хуулийн этгээдэд ямар нэгэн зардал үүсэхгүй болно.

3.Хуулийн төсөлд тусгагдсан хуулийн заалттай холбоотой иргэнээс гарах зардал үүсэхээргүй байна.

Тус хуулийн төсөл батлагдсанаар гарах зардал нь үр өгөөжтэй харьцуулахад үлэмж бага буюу үр ашиг зардлын харьцаа өндөр байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Хууль тогтоомжийн тухай хууль;
2. *Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”;*
3. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”;
4. <https://mddc.gov.mn/mn/>
5. <https://itpark.mn/>
6. [Статистикийн мэдээллийн нэгдсэн сан \(1212.mn\)](#)

---oOo---

